МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Санчир Түвдэн

Он сар өдөр, төрсөн газар	1926, Дундговь аймаг, Луус сум
Үндсэн сүм хийд	Талын хурал
Б.Ринченгийн сүм, хийдийн нэр	Талын хурал
Ярилцлаганд дурдагдсан бусад сүм хийдүүд	Цагаан хадны хийд, Бор овооны хийд, Чойрын хийд, Бороогийн хурал

Дундговь аймгийн Өлзийт сумын Талын хурал, Хөтлийн жас, Цагаан хадат

- Хэдэн дуган дацантай байв?

Цогчин дуган, Дарь эхийн дуган гэсэн хоёр дугантай л байсан.

- Дуганууды юугаар барьсан байсан бэ?

Хоёулаа тоосгон дуган байсан. Одоо хүртэл нэг дуганын нь ханын үлдэгдэл байгаа. Нэг нь улаан тоосго, нөгөө дуганыг нь хөх тоосгоор барьсан байсан. 1938 онд энэ хурал хаагдсан. /Өвгөн хоёр дуганы байршлыг зурж үзүүлж байгаа бололтой иймэрхүү хэлбэр байрлалтай байсан гэж өгүүлж байна./

- Нөгөө Хөтлийн хурал энэ хоёр хоорондоо хэр ойрхон байсан бэ?

/Бодолхийлснээ/ 20 орчим км зайтай юм уу даа. Хөтлийн хийд нь 150-иад ламтай, их бага хоёр дуган гэж байсан юм. Нэг нь л лав Цогчин дуган, нөгөөх нь одоо Дарь эхийн дуган байсан юм уу даа.

- Энэ хоёр дуган ямар байрлалтай байсан юм бол?

Зүүн талд нь Цогчин дуган, баруун талд нь Дарь эхийн дуган байсан.

- Суварга байсан уу?

Байсан, хоёр... үгүй ээ, гурван суварга байсан юм байна. Хойноо нэг, баруун хойноо нэг, урдаа нэг суварга байж. Бас бархан гэж мэднэ биз дээ, ном судар хийдэг. Тийм юм байсан. Талынхад ч бас байсан юм гэнэ лээ. Бас Бор овооны хийд гэж байсан. Эндээс 30-аад км зайтай газар. Би очиж үзээгүй. Хорь, гучаад ламтай, нэг сүмтэй газар байсан юм гэнэ лээ. Энүүхэн энд бас нэг хийд байсан юм гэнэ лээ.

- Ямар нэртэй? Цагаан хадны хийд гэж?

Тийм, Цагаан хадны хурал. Энэ чинь Өлзийт сумнаас зүүн тийшээ.

- Ямар хийд байсан юм бол?

Би сайн мэдэхгүй юм, хэдэн ламтайг нь. Хоёр сүмтэй л байсан юм гэсэн. 21 цам гардаг байсан гэж байгаа. Энэ Хөтлийн хийд ч бас 21 цамтай байсан гэдэг.

- Хэдүүд энэ хурлууд хаагдсан юм бол?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Ерөнхийдөө бол 38, 39 онд нарыг нь барьж тараагаад л хаагдсан. Тэгээд дөчөөд оноос л нураагдаж эхэлсэн дээ.

- Ямар ямар хурал голчлон хурж байсан юм бол оо?

За Талынхад лав л Арван хангал, Хайлан, Цогчин хурдаг байсан. За ерөөл магтаал хурдаг л байсан байлгүй. Ганжуур данжуурын том том боть зөндөө л байсан, эргэдэг л байсан байх.

- Майдар эргэх үү?

Майдар эргэнэ ээ, сор зална.

- Зоч лам нар байсан уу?

Байсан. Талын хийдэд Далангаа зоч гэж сайн зоч байсан. Гүртэн хүн, мэднэ биз дээ. Хуралд суудаггүй. Бас Дамдин зоч гэж байсан. Энэ Хөтлийн хуралд зоч байсан юм уу, би сайн мэдэхгүй.

- Хамба лам гэж байсан уу?

Үгүй ээ , байгаагүй.

- Талын хурлын тэргүүн лам нь хэн гэж байсан бэ?

Талын хурлын тэргүүн лам нь Гүнчин гэлэн гэж байсан. Энэ Хөтлийн хурлын тэргүүн хэн гэж байсныг мэдэхгүй. Цагаан хаданд Намжил ловон гэж байсан. Талын хурлын гэсгүй нь Жунай гавж, Хөтлийн хийдийн гэсгүй нь Гүрдорж зурхайч гэж лам нар байсан.

- Хурал хийдийг дагаад харчуул борчуул зөндөө байсан биз дээ?

Өө, харчуул борчуул зөндөө байсан. Харчуул гэж мал алж, ан хийдэг хүмүүс, борчуул гэж ядуу зүдүү амьдралтай айл өрхүүдийг хэлж байсан.

- Энд Хятадууд байсан уу?

Өө хятадууд байсан. Энэ хоёр хийдийн дунд том өртөө байсан юм. Энүүгээр хятадууд нааш цаашаа их цувна, худалдаа наймаа хийнэ. За, миний мэдэх юм, товчхондоо нэг иймэрхүү л байна даа. Сайн мэдэх хүмүүс нь ч одоо ховордож дээ.

- Хайлан хурж байсан гэсэн?

Хайланг 45 хоног хурна. Их том хурал болно.

- Энэ хийдүүдэд Төвдөөс бас Богдын хүрээнээс том том лам нар ирж байв уу?

Үгүй үгүй, би мэдэхгүй. Харин Заваа Дамдин гавж энэ урагшаа Манлайн Ханбогдын Улаан сахиусын хийд, Дэмчигийн хийд рүү явахдаа замдаа дайрч бууж, хоноглож хурал хурж байсан юм гэдэг. Бас энэ хойд Луусын хийдийн Чойжоо билүү, тэр гавж ирж лам нартай ном хурдаг байсан гэнэ лээ.

- Та Хар ноёны хийдийн тухай хэр мэдэх вэ?

Өө мэдэхгүй. Дайчин бэйсийн хошууны ноёны хийд юм л гэж сонссон.

- Тэр хошууны ноёны нэр хэн бэ?

Одоо санахгүй байна, санахгүй байна.

- Танай хийдийн лам нар ямар сууцанд амьдарч сууж байв?

Зундаа гэрт, өвөл шавар байшинд суудаг байсан. Түүхий тоосгоор барьсан шавар байшин гадуураа тийм шавар хэрэмтэй. Тэгээд л намар хайлан хурж дуусаад л шууд байшиндаа ордог. Хавар сүүлээр зуны эхэн сарын өмнө гэр барьж гарцгаадаг байсан.

- Хүрднүүд байсан уу?

Өө байсан байсан. Их л том том хүрднүүд байсан. Тоог нь мэдэхгүй, тойроод л байдаг байсан.

- Суварганууд хэр байсан?

Өө суварга сүмээ тойроод л одоо гурав дөрөв байдаг байсан. Энэ сүмийн үүдэнд хоёр том хүрд лав байсан.

- Ямар ямар овоо тахидаг байсан бэ?

За энэ Талын хурал нь болохоор тэр зүүн урд Талын баян гэж овоо, урагшаагаа Талын богд гэж хайрхан, хойшоогоо Баян овоо, за энэтээ Тахилгат гэж овоо, ийм овоонуудыг тахидаг байсан. Хөтлийн хурал

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

баруунтаагаа Буянт овоо, үгүй ээ тэгээд Хөтөлд өөр овоо мэдэхгүй юм аа. Өөр одоо ер ямар овоо тахиж байсан юм бол, Буянтаас өөр. Чухам тэр Хар овоо гэж байгаа, түүнийг тахиж байсан юм уу, үгүй юм уу мэдэхгүй.

- Энэ лам нарын дотор гэлэн, гэвш сахилтай лам нар хэр олон байсан бол?

Өө олон байсан. Тэр гэлэн гуай энэ гэлэн гуай гээд л олон гэлэн байсан. Ганц нэг гэвш ч байсан. Миний эцгийн ах Лхасүрэн гавж гэж хүн байсан. Бас манай хамаатны хүн юм гэнэ лээ, Цэдэндорж бил үү, Цэдэндаш бил үү, хазгардуу хүн аграмба болоод Өлгийн хийд дээр аграмба болоод ирж байсан юм аа.

- Ер нь энэ аймагт хамгийн том хийд нь ямар хийд вэ?

Дэлгэрцогтын Чойрын хийд юм даа. Шинэ Шавийнхан гэж ярьдаг, шинэ Чойр ч гэж ярьдаг. Бас энэ Өлгийн хийд юм уу даа, миний мэдэхийн.

- Энэ Өлгийн хийдэд Чойрын ном байсан уу?

Байсан байсан. Тэр гавжийн аграмбын дамжаа барина гэдэг чинь чойрын ном л үздэг байсан. За тэгээд энэ Талын хурал, Хөтлийн хурал, Цагаан хадны хурал, Бороогийн хурал чинь бүгд жасаа хурал л юм даа.

- Та хэдэн онд төрсөн бэ?

1926 онд төрсөн.

- Хэдэн онд яг энэ Талын хуралд шавилж сууж байсан бэ, хэдэн жил суусан бэ?

6 настайдаа суусан. 1939 онд хар болсон гэхээр хэдэн он байх вэ. Тэгэхээр 1932-1939 он хүртэл долоон жил болж байна уу.

- Таныг овог хэн бэ?

Санчир.

- За, та Талын жасын тухай энд Цогчин дуган, энд Дарь эхийн дуган, энд суварга, энд хүрд байсан гээд бүдүүвч зураг гаргаж чадах уу?

Чадна, чадна. Хаана зурах вэ, тэгье, наад цаасан дээр чинь зуръя. / Бүдүүвч зураг гаргуулав./

- Энэ шинэ хийд хэдэн онд байгуулагдсан бэ?

Бүүвэйбаатар: 1990 онд байгуулагдаж анхны хурлаа хийж эхэлсэн юм. Энэ шавар гэр дуган чинь анх манай сумын музей байсан юм. Тэгээд 1990 онд музей татан буугдаж сумын сүсэгтний холбоонд өгснөөр гэр дуган болгож ашигласан.

- За анх хичнээн ламтай байгуулагдсан бэ?

Бүүвэйбаатар: 70-90 насны дөрвөн ламтай, 2-3 бандитай хурал эхэлсэн.

- Анхны хамба лам нь хэн бэ?

Бүүвэйбаатар: Тийм хамба гэж байгаагүй. Ерэн дөрөв таван настай Лувсангомбо гэдэг өвгөн л хурлыг тэргүүлж байсан. Өвгөнийг өнгөрснөөс хойш уг нь эцэг нь манай эндхийнх, Санжаадорж гэж лам залуу одоо аймагт байдаг, тэр лам л онцгой дүйчэн өдрүүдээр ирж хурал хурдаг. Овоо тахина. Манайхан чинь энэ өмнө талын цагаан овоо, тэр баруунтаа Хулдын наад талын Луус хайрхан уулаа тахидаг юм. Энэ хуучин Луусын хийдийн түүхэн баримт мэдээ сурвалж надад дээр үед өвгөчүүдээс бичиж тэмдэглэж хуулж авсан юмнууд бий. Би та нарт түүнийг үзүүлье. Бас багадаа Луусын хийдэд шавилж байсан Догсом гэж өндөр настай өвгөн энэ гэртээ байна уу, үгүй юу. Тэр хүн эрх биш зарим зүйлийг маниас илүү мэдэх байх. Энэ Өлзийтийн хийд гэдэг чинь сумын төв байгаа газраа байсан юм. Түүнийг Өлзийт орохоороо асууж сураглана биз. Бас өндөр настай лам нар ховордсон. За тэгээд миний мэдэх юм ингээд дууслаа.

- Их баярлалаа.

Ярилцсан: М.Жужа, Т.Кристина, О.Энхбаяр

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон